

## “ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрхэм хувьцаа эзэмшигчдээ.

Манай хувьцаат компани 2019 онд авто зам, гүүрийн ажил хийгээгүй бөгөөд 2018 онд хийж гүйцэтгэсэн “Хараа голын төмөрбетон гүүрийн ажил 153,3 у/м /Дархан уул, Дархан сум/ ажлын үлдэгдэл төлбөр болох 368 390 108.50 төгрөгийг захиалагчаас авсан.

Тус онд нийт 19 ажилтан албан хаагчтайгаар ажилласан бөгөөд 79 340 428.76 төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлсийн ажилчдад цаг тухайд нь олгож, цалин хөдөлмөрийн хөлс болон Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй ажиллаж байна.

Бид 2019 онд “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам”-ын ажилд туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулан 2020 онд гүйцэтгэхээр 417 085 634 төгрөгийн урьдчилгаа төлбөр аваад байна.

Компани татвараа үнэн зөв тодорхойлж, төлөх тайлагнах үүргээ нэр төртэй биелүүлж, нийгмийн хариуцлагаа ухамсарлаж ААНОАТатварт 145 796 төгрөг, НДШимтгэлд 30 419 129.77 төгрөг, ХХОАТатварт 6 322 854 төгрөг, НӨАТатварт 13 741 479 төгрөг, газрын төлбөрт 6 225 685, ҮХЭХАТатварт 2 167 047.68 төгрөг, 2019 оны 12 дугаар сарын байдлаар нийт 59 021 991.45 төгрөгийн татвар төлжээ.

Манай компани 2020 онд нийслэл болон орон нутгийн авто зам, гүүрийн ажлын тендерт оролцон борлуулалтын орлогоо тогтвортой өсөн нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгох, өглөг авлагын хэмжээг бууруулах, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА